



Унгар улсын Будапешт хотын Өтвөш Лорандын нэрэмжит Их Сургуульд

2022 оны 10 дугаар сарын 20–21 өдөрт болох

“МОНГОЛЫН БУРХНЫ ШАШИН: АМЬТАН, УРГАМАЛ БА БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ”

сэдэвт монголын бурхны шашны олон улсын эрдэм

шинжилгээний IV хуралд оролцохыг урьж байна.



Унгарын орчин үеийн монгол судлалыг үндэслэгч нэрт монголч эрдэмтэн, академич, профессор Лайош Лигетигийн (Ligeti Lajos / Louis Ligeti, 1902–1987) мэндэлсний 120 жилийн ой болон Өтвөш Лорандын нэрэмжит их сургуулийн сургалтын хөтөлбөрт монгол судлалыг оруулсны 90 жилийн ойг энэ жил тэмдэглэж байна. Эдгээр Унгар дахь монгол судлалын түүхэн үе шатыг дурсах олон төрлийн үйл ажиллагаа, үзэсгэлэн, эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж байна.

Монголын бурхны шашны сэдвээр олон улсын эрдэм шинжилгээний IV хурлыг 2022 оны 10 дугаар сарын 20–21-ний өдрүүдэд зохион байгуулах бөгөөд эдгээр арга хэмжээнд хувь нэмрээ оруулахыг хүсье. Уг эрдэм шинжилгээний хурлыг Өтвөш Лорандын нэрэмжит их сургуулийн Монгол ба Төв Ази судлалын тэнхим, Монгол судлалын төв, Буддын шашны судлалын төв зохион байгуулах бөгөөд Унгарын Шинжлэх Ухааны Академийн Номын сан, мэдээллийн төвийн Дорно дахины цуглуулга, Хопп Ференцийн нэрэмжит Азийн урлагийн музей, “Номын үүд” Буддын сүм, Монгол Улсаас Унгар Улсад суугаа Элчин Сайдын Яам, МБШТ Гандантэгчэнлин хийд зэрэг байгууллагууд зохион байгуулахад хамтарч ажиллана.

Монголын бурхны шашны олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2015 онд “Өнгөрсөн, одоо, ирээдүй”, 2017 онд “Бурханы шашны зан үйл”, 2019 онд “Уламжлал ба шинэчлэл” гэсэн сэдвүүдээр гурван удаа амжилттай зохион байгуулжээ. Монголын бурхны шашны эрдэм шинжилгээний IV хурлыг 2022 оны 10 дугаар сард “Ургамал, амьтан ба байгаль хамгаалал” сэдвийн хүрээнд зохион байгуулахаар төлөвлөж байна. Энэхүү хурал нь: хүрээ хийд, лам хувраг, сүсэгтэн ард иргэд хүрээлэн буй байгаль дэлхийтэйгээ өнө удаан, нарийн шүтэлцээтэй явж ирснийг илтгэхийн ялдамд эрдэмтэн судлаачид, лам хуврагууд хурлын сэдвийн хүрээнд өөрсдийн судалгааны сэдвийг танилцуулж, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулж, санал бодлоо солилцох таатай боломж бүрдүүлэхийг зорьж байгаа болно. Мөн энэ сэдэв нь “Монголчуудын шашин шүтлэгийн хүрээнд хэрхэн соёл ба байгаль хоорондын харилцан нөлөөлөл” нэрийн дор хэрэгжиж буй Монгол ба Төв Ази судлалын тэнхимийн төсөлтэй холбоотой байгаа юм.

Хурлын түүхэн царга хүрээ нь байгаль дэлхийд шүтэн оршсон, өөрийн дагагч шавь нартаа хүрээлэн буй байгаль дэлхийг хайрлан дээдлэхийг уламжлуулсан Бурхан багшийн замнал юм.

Бурхны шашны чухал бэлгэдэл болсон бодь гөрөөс оршсон аглаг ойд тэрээр анхны номын хүрдийг эргүүлсэн байдаг. Амьд амьтны амь таслахыг цээрлэх явдал нь энэрэн нигүүлсэхүй бодийн сэтгэл дээр шүтсэн Бурхан багшийн үзүүлсэн номлол бөгөөд энэ нь мал амьтан, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, хүрээлэн буй орчинтойгоо зөв харьцах ёс зүйт ухамсар мэт ойлгогдож байна. Монголчууд байгаль дэлхийтэйгээ бие махбодоороо нягт холбоотой аж төрдөг ба нутаг орны амин сүнс болох газрын эздийг аргадан тайтгаруулаж, аль болох хохирол учруулж сүйтгэхээс зайлсхийдэг ард түмэн билээ. Мөн амьтны амийг дархлахдаа хадаг яндар зүүн чимдэг. Бурхны шашны олон төрлийн сахиусуудыг уул хангайд оршдог гэж үздэг байна. Монголчуудын дунд, өвс ургамал, мал амьтан, байгаль дэлхий бол шашин, соёл урлаг, уламжлалт нүүдэлчний амьдралтай нь бүхий л талаараа салшгүй холбоотой бөгөөд жишээ нь аман зохиолын үзүүлбэр, уламжлалт анагаах ухааны дадал, мал аж ахуйн амьдралын хэв маяг, түүнтэй холбоотой ёс заншил, цээрлэх ёсон зэрэг юм. Илтгэл нь хурлын талаарх бүх сэдвээр байж болох бөгөөд



үүнд шашны зан үйл, боловсрол, ёс заншил, урлаг, эх бичиг, ардын аман зохиол, байгаль дэлхийтэй барилдсан Монголын бурхан шашны түүхэн болон өнөө цагт холбогдох бусад судалгааны сэдвүүд байж болох юм.

Энэхүү эрдэм шинжилгээний хурлаар өнөөгийн Монголын нутаг дэвсгэрт амьдарч буй Монголчуудын бурхан шашин Орос, Хятад болон бусад газарт амьдарч буй монгол угсаатнуудын итгэл үнэмшил, ёс заншлын талаар хэлэлцэх бөгөөд байгаль дэлхийд хандсан Монголын уламжлалт бурхны шашны өвөрмөц онцлогийг хуралд танилцуулагдах илтгэлүүдээр нээн харуулах болно.

Эдгээр шинжлэх ухааны бүтээлүүд нь англи хэл дээр эмхтгэл болон хэвлэгдэнэ.

Хурлын үеэр зохион байгуулагчид хөнгөн зуушаар хангах болно. Мөн оролцогчид байх хугацааны аялал болон орон сууцыг бие даан хариуцах шаардлагатай. Хэрэв оролцогч та бүхэнд байрлах байрны талаар туслалцаа хэрэгтэй бол зохион байгуулагчдад хандаж болно.

Олон улсын эрдэм шинжилгээний хурал англи, монгол, орос хэлээр явагдах болно.

Хуралд оролцогч та бүхэн хурлын өмнөх өдөр буюу 10 дугаар сарын 19-ний өдөр Унгарын Шинжлэх Ухааны Академийн Номын сан, мэдээллийн төвийн Дорно дахины цуглуулгын цоморлиг болон Хопп Ференцийн нэрэмжит Азийн урлагийн музейд гарч буй монгол соёлын тухай “Yurts and Monasteries” үзэсгэлэнг үзэх боломжтой.

Илтгэлийн нэр болон хураангуйг 150 үгэнд багтаан 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор mongol@btk.elte.hu цахим хаягаар илгээнэ үү! Хэрвээ танд виза авахад шаардлагатай урилга хэрэгтэй бол бидэнд мэдэгдэнэ үү!

2022 оны 5 дугаар сарын 15, Будапешт хот

Зохион байгуулах хорооны нэрийн өмнөөс:

Бирталан Агнеш, тэнхим болон судалгааны төвийн эрхлэгч